



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/346

Мандалговь

Соёлын хэлтэс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, 65 дугаар зүйлийн 65.1.8, Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 168 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний Соёлын хэлтсийг байгуулсугай.
2. Соёлын хэлтсийн бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.
3. Аймгийн Боловсролын газраас Соёлын өв хариуцсан мэргэжилтэнд чиг үүрэг, орон тоо цалингийн сан, түүнд ногдох үйл ажиллагааны зардлын хамт Соёлын хэлтэст шилжүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Боловсролын газар (Ц.Уранбямба) нарт үүрэг болгосугай.
4. 2021 оны төсөвт зохицуулалт хийж Соёлын хэлтсийн албан хаагчдын цалин хөлс холбогдох зардлыг шийдвэрлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



481210061